



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ  
ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**“ШҮҮГЧ НАРТ СЭТГЭЛ ЗҮЙН  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА,  
ХАМРАГДАХ НӨХЦӨЛ БОЛОМЖ”**

---

Санал асуулгын судалгааны тайлан

Улаанбаатар хот  
2019 оны 4-р сар

---

## АГУУЛГА

Удирдтал .....	3
1. Судалгааны зорилго ба хамрах хүрээ (судлах зүйл) .....	3
2. Судалгааны мэдээлэл цуглуулах арга .....	3
3. Судалгааны онол аргазүй .....	3
4. Судалгааны түүвэр .....	3
5. Судалгааны мэдээлэл цуглуулалт ба мэдээллийг боловсруулсан байдал .....	4
6. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийн хэсэг .....	4
Нэг. Шүүгчийн ажил мэргэжилтэй холбоотой үүсэх бэрхшээл саад, бие махбод болон сэтгэл зүйн стрессийн шинж, тэдгээрийг даван туулах арга зам .....	5
Хоёр. Сэтгэл зүйн үйлчилгээний хэрэгцээ шаардлага, хамрагдсан байдал, үр нөлөө .....	10
Дүгнэлт .....	15
Санал зөвлөмж .....	16



## Удирдтал

### 1. Судалгааны зорилго ба хамрах хүрээ (судлах зүйл)

“Шүүгч нарт сэтгэл зүйн үйлчилгээний хэрэгцээ шаардлага, хамрагдах нөхцөл боломж”-г судалж, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх хэрэгцээ шаардлага, арга зам, хамрагдах нөхцөл боломжийг тодорхойлж, санал дүгнэлт өгөхөд судалгааны зорилго оршино.

Дээрх зорилгод үндэслэн шүүгч нарын сэтгэл зүйн байдал, сэтгэл зүйчид хандах хандлага, хамрагдах хүсэл сонирхол, үүсэх бэрхшээл саадыг дараах байдлаар томъёолж, судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулан мэдээлэл авч, үр дүнд тулгуурлан тайланг боловсрууллаа.

*Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдах объектив хүчин зүйлс:*

- Ажлын ачаалал, мэргэжлийн онцлог;
- Шүүгчээр ажилласан жил, эрх зүйн дагнасан төрөл;
- Нийгэм, улс төр болон олон нийтийн хандлага;
- Шүүгчийн нэр хүнд, хараат бус байдал;
- Сэтгэл зүйчид хандах нөхцөл боломж.

*Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдах субъектив хүчин зүйл:*

- Хувь хүний өөрийгөө удирдах, хянах чадвар;
- Чөлөөт цаг болон сонирхол хобби;
- Ажил мэргэжилдээ хандах хандлага;
- Зөрчилт байдлыг шийдвэрлэх арга барил;
- Өөртөө итгэх итгэл, айдас, стрессийн түвшин.

*Байгууллагын удирдлага, зохион байгуулалт:*

- Сэтгэл зүйн сургалт, уулзалт ярилцлага зохион байгуулсан эсэх;
- Хамт олны уур амьсгал, нэгдэл нягтрал;
- Албан ба албан бус байдлаар сэтгэл зүйн мэдээлэл түгээх.

### 2. Судалгааны мэдээлэл цуглуулах арга

Судалгааг анкетын судалгааны хэлбэрээр авсан бөгөөд асуултуудыг хаалттай, хагас хаалттай болон нээлттэй байдлаар томъёолон хийсэн болно. Судалгааны үр дүнд шүүгч нарт сэтгэл зүйн үйлчилгээний хэрэгцээ шаардлага байгаа эсэх, шүүгчээр ажиллахад үүсч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдэхэд тэдний оролцоог нэмэгдүүлэн санал бодлыг тусгах зорилгоор нээлттэй болон хагас хаалттай асуултуудыг түлхүү ашигласан болно.

### 3. Судалгааны онол аргазүй

- Шаталсан хэрэгцээний онол;
- Социал когнитив онол;
- Нийгэм-соёлын онол.

### 4. Судалгааны түүвэр

Судалгааны түүвэр: Бүх шатны шүүхийн шүүгч нараас нэлэнхүй байдлаар судалгааны анхдагч мэдээллийг цуглуулав.

Мэдээллийн нууцлалыг хангах: Судалгааны мэдээллийг цуглуулахдаа анкетыг байгууллагын дотоод сүлжээг ашиглан онлайн хэлбэрээр респондентод хүргэсэн. Түүнчлэн хариулт бүхий мэдээллийн нууцыг хамгаалах үүднээс судалгааг авахдаа хүн тус бүрийг дугтуйнд хийж битүүмжлэн буухиа шуудангаар ирүүлүүлсэн болно.

## 5. Судалгааны мэдээлэл цуглуулалт ба мэдээллийг боловсруулсан байдал

Судалгааны мэдээллийг шүүгч нар аль болох бусдын нөлөөлөлд автахгүй, өөрийн үзэл бодлоо нээлттэй, шударгаар илэрхийлэх боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх замаар цуглуулсан бөгөөд мэдээллийн сан хийгээд харьцуулсан тоололтыг SPSS програм дээр боловсрууллаа.

## 6. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийн хэсэг

Монгол Улсын хэмжээнд 2019 оны 3 дугаар сарын байдлаар нийт 508 шүүгч ажиллаж байна. Санал асуулгын судалгаанд өвчтэй, чөлөөтэй, томилолт авсан шүүгчид хамрагдаагүй болно. Нийт 357 асуулгын хариу ирснээс 1 асуулга шаардлага хангах боломжгүй тул хасч, 356 асуулгыг ашигласан болно. Энэ нь хамрагдалтын түвшин нийт шүүгчдийн 70.1 хувь байна.

График №1.





График №2.



Хүснэгт №1.


Шүүгчээр ажилласан

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь
1	1 хүртэлх жил	9	2,6%
2	2-5 жил	88	25,9%
3	6-10 жил	53	15,6%
4	11-15 жил	83	24,4%
5	16-24 жил	51	15%
6	25 ба түүнээс дээш жил	56	16,5%
7	Нийт хариулт өгсөн	340	100%
8	Хариулаагүй	16	
	<b>Нийт</b>	<b>356</b>	

Судалгаанд оролцсон шүүгчдийн 29.0 хувь нь 5 хүртэл жил, 71.0 хувь нь 6-аас дээш жил шүүгчээр ажилласан байна. Удаан хугацаанд шүүгчээр ажиллах нь хувь хүний өөрийгөө удирдан жолоодох чадвар, шударга оновчтой шийдвэр гаргах мэдлэг туршлага, сэтгэл зүйн тогтвортой байдал, аналитик оюуны үйлдэлд дадал бий болох зэрэг олон эерэг нөлөөтэй юм. Шүүгчээр ажилласан туршлага мэдлэг чадвар нь сэтгэл зүйн хувьд бие даасан, хараат бус, өөртөө итгэлтэй, асуудалд бодитой хандах чухал хүчин зүйл болно. Үүнийг графикаар дэлгэрэнгүй авч үзвэл

График №3.

Шүүгчээр ажилласан жил



**Нэг. Шүүгчийн ажил мэргэжилтэй холбоотой үүсэх бэрхшээл саад, бие махбод болон сэтгэл зүйн стрессийн шинж, тэдгээрийг даван туулах арга зам**

Хүснэгт №2. Өөрийн ажил, мэргэжилтэй холбоотой бэрхшээлтэй асуудал үүсдэг үү?

№	Асуудал, бэрхшээл	Үгүй	Бага зэрэг	Ихэвчлэн	Байнга
1	Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх	35.90%	51.10%	10.90%	2.00%
2	Дээд байгууллага, албан тушаалтнаас ирэх дарамт шахалт	79.30%	19.00%	1.20%	0.60%
3	Хамтран ажиллаж байгаа хүмүүсийн алдаа дутагдал	34.00%	58.40%	7.30%	0.30%
4	Өөрийн гаргасан шийдвэртээ хувь хүний хувьд эмзэглэх, шаналах	43.50%	51.30%	4.10%	1.20%
5	Ажлын ачааллаас үүдэлтэй уурлах, бухимдах, өөрийн хяналтаа алдах	45.70%	46.30%	6.90%	1.10%
6	Мэдлэг, туршлага дутмаг байгаагаа мэдрэх	45.80%	51.00%	2.30%	0.90%
7	Олон нийтийн сөрөг хандлага, хардаж сэрдэх байдал, шүүгч мэргэжлийн үнэлэмж	11.80%	50.30%	29.90%	8.00%
8	Ажлын уялдаа холбоо, зохион байгуулалт	42.90%	42.60%	11.30%	3.10%
9	Төвөгтэй нөхцөлд оновчтой шийдвэр гаргах мөч	29.40%	52.60%	12.20%	5.80%
10	Нэг ажлыг удаан хугацаанд хийх	53.20%	32.70%	10.20%	3.90%
11	Бусдын өмнө өндөр хариуцлага хүлээх	32.30%	31.70%	15.90%	20.10%
12	Ажлаа хийх урам зориг үгүй болох \ажлаас халшрах\	62.60%	32.50%	3.80%	1.20%
13	Ажлын онцлогийг нөхөр\эхнэр ойлгохгүй байх	73.90%	19.80%	5.20%	1.10%
14	Нийгэм, бусад хүмүүсээс тусгаар байдал	25.50%	37.10%	19.90%	17.50%
15	Олон төрлийн зан ааштай хэргийн оролцогчидтой харилцах	19.50%	43.00%	21.50%	16.00%

Шүүгч нарын ажил мэргэжлийн онцлогтой холбоотойгоор байнга үүсдэг бэрхшээлтэй асуудал нь бусдын өмнө өндөр хариуцлага хүлээх байдал 20.1 хувь, нийгэм, бусад хүмүүсээс тусгаар байдал 17.5 хувь, олон төрлийн зан ааштай хэргийн оролцогчидтой харилцах нь бэрхшээл үүсгэдэг 16.0 хувь гэж хариулсан байна.

Харин дээд байгууллага, албан тушаалтнаас ирэх дарамт шахалт огт байхгүй 79,3 хувь, гэр бүл болон хань, үр хүүхэд нь ажил мэргэжлийн онцлогийг ойлгож дэмждэг нь 73.9 хувь байна. Олон нийтийн сөрөг хандлага, хардаж сэрдэх байдал шүүгчийн нэр хүндэд халдах байдал бага зэрэг бэрхшээл болдог гэж 80.2 хувь хариулсан байна.

*Хүснэгт №3 Ажил үүргээ гүйцэтгэх явцад стресс бухимдалтай байгаагаа ямар үед мэдэрдэг вэ?*

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь (тоололт)	Хувь (хүн)
1	Өмнөх шүүх хурлын үеэр бий болсон стресс дараагийн шүүх хурал дээр үргэлжлэх үед	72	17.8%	22.1%
2	Удирдлага доорх болон бусад хүмүүстэй харилцах үед	68	16.8%	20.9%
3	Гэр бүлийн таагүй харилцаа асуудал үүсэх үед	45	11.1%	13.8%
4	Ажлын ачааллаас шалтгаалан гар дээрх хэргүүд олшрох, хэргийн хуулийн хугацаа тулах, амжихгүй байх үед	178	44.1%	54.6%
5	Одоогоор стресс байхгүй	41	10.1%	12.6%
	<b>Нийт</b>	<b>404</b>	<b>100%</b>	

Шүүгч нарын өдөр тутмын ажлын ачааллаас шалтгаалан гар дээрх хэргүүд олшрох, хэргийн хуулийн хугацаа тулах, амжихгүй байх үед стресс бухимдалтай байгаагаа мэдэрдэг 54,6 хувь, одоогоор стресс бухимдал байхгүй гэж 12,6 хувь хариулсан байна. Энэ нь ажлын ачааллаас үүдэн илүү цагаар ажиллах, амралтын өдөр ажлаа хийх гэх мэт амрах нөхцөл боломж бага байгаагаас эрүүл мэнд болон сэтгэл зүйн стресст орж байна.

*Хүснэгт №4*

*Ажлын энэ нөхцөл байдал үүсэхэд ямар арга хэмжээ авдаг вэ?*

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь (тоололт)	Хувь (хүн)
1	Өөртөө хадгалж үлдээд хэсэг хугацааны дараа мартдаг	268	37.8%	77.7%
2	Хамт олон мэргэжил нэгт хүмүүстэй ярилцаж, зөвлөгөө авдаг	161	22.7%	46.7%
3	Гэр бүлийн хүнтэйгээ ярилцдаг	47	6.6%	13.6%
4	Дотно найз нөхөдтэйгээ ярилцаж тайвширдаг	39	5.5%	11.3%
5	Хэнд хандаж, хэнтэй хуваалцахаа мэддэггүй	35	4.9%	10.1%
6	Гадаа гарч алхах, тамхи татах, кофе уух, тоглоом тоглох г.м.	17	2.4%	4.9%
7	Спортоор хичээллэдэг	110	15.5%	31.9%
8	Байгаль, аялал, ном унших, бясалгал, иог, кино үзэх	32	4.5%	9.3%
	Ажлын онцлог, юу ч бодохгүй хичээдэг			
	<b>Нийт</b>	<b>709</b>	<b>100%</b>	

Ажил, мэргэжлийн онцлогоос хамаарч үүссэн сэтгэл зүйн асуудлаа өөртөө хадгалж үлдээд, ганцаараар байж хэсэг хугацааны дараа тайвширдаг 77,7 хувь, хамт олон мэргэжил нэгт хүмүүстэй ярилцаж зөвлөгөө авдаг 46,7 хувь байна. Энэ нь шүүгчийн ажил мэргэжлийн онцлог, бие даасан хараат бус байдал болон нийгэмд эзлэх байр суурьтай холбоотой юм.

График №4.

Бэрхиээлтэй асуудлаас гарах арга зам



Сүүлийн 2 сарын хугацаанд ажлын стрессээ тайлах, өөрийгөө хөгжүүлэх, зорилгоор чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлснийг тодруулахад:

Хүснэгт №5 Сүүлийн 2 сарын хугацаанд ажлын стрессээ тайлах, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор ямар арга хэмжээ авсан бэ?

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь (тоололт)	Хувь (хүн)
1	Гэр бүлээрээ амрах, салхинд гарах, тоглоом тоглох	171	21.70%	49.70%
2	Ном унших, сонирхолтой өөрт хэрэгтэй мэдээлэл авах	133	16.90%	38.70%
3	Өөрийн сонирхсон спортоор хичээллэх	110	14.00%	32.00%
4	Сургалт семинар, уулзалт ярилцлаганд суух	41	5.20%	11.90%
5	Ажил, амьдралын хэв маягаа өөрчилж, шинэ хэв маягийг туршиж байгаа	34	4.30%	9.90%
6	Найзуудтайгаа уулзаж, ярилцсан	60	7.60%	17.40%
7	Хамт олны нэгдсэн арга хэмжээнд оролцсон	72	9.10%	20.90%
8	Гадаад төрх, гоо сайхан, алжаал тайлах, дэлгүүр хэсэх г.м.	50	6.40%	14.50%
9	Шинэ кино, үзвэр үйлчилгээ үзэх	56	7.10%	16.30%
10	Ямар нэгэн үйл ажиллагаанд оролцоогүй	47	6.00%	13.70%
11	Бусад	13	1.70%	3.80%
	<b>Нийт</b>	<b>787</b>	<b>100.00%</b>	

График №5.

Таны юунаас урам зориг авдаг вэ?



График №6.

Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?



Шүүгч нарын урам зориг авдаг хамгийн чухал зүйл нь тэдний гэр бүл, үр хүүхэд 40.0 хувь байна. Гэр бүлээрээ амрах, аялалаар явах 49.7 хувь, ном унших, хэрэгтэй мэдээлэл авах 38.7 хувь, өөрийн сонирхсон спортоор хичээллэдэг 32.0 хувь байна. Энэ нь чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг тухай мэдээллээр улам баталгаажиж байна.

Шүүгч нар ажлын ачаалал, ажил мэргэжлийн онцлогоос үүссэн сэтгэл зүйн аливаа асуудлаа өөрөө бие даан шийддэг бөгөөд гэр бүлээрээ амарч зугаалах, эсвэл гэртээ амар тайван байхыг чухалчилдаг нь харагдаж байна.

Хүснэгт №7

Сүүлийн 6 сарын хугацаанд ажил, мэргэжлийн ачаалалтай холбоотойгоор таны бие махбод, сэтгэл зүйд илэрч буй шинж тэмдэг?

№	Бие мах бодын хувьд	Тийм	Үгүй
1	Нойргүйдэл	56.20%	43.80%
2	Толгой өвдөх	55.00%	45.00%
3	Зүрх дэлсэх	41.20%	58.80%
4	Даралт ихсэх, багасах	39.80%	60.20%
5	Хоолны дуршил буурах, ихсэх	16.10%	83.90%
6	Ходоод өвдөх, хоолны шингэц муудах	25.80%	74.20%
7	Хэт таргалах	22.30%	77.70%
8	Дааврын өөрчлөлт ажиглагдах	11.90%	88.10%
9	Амархан ядрах сульдах	56.40%	43.60%
10	Хөлс их хэмжээгээр ялгарах	17.90%	82.10%
11	Бэлгийн дур хүсэл буурах	9.50%	90.50%

Хүснэгт №8.

№	Сэтгэл зүйн хувьд	Тийм	Үгүй
1	Ой тогтоолт муудах	31.30%	68.70%
2	Түрэмгий догшин авир төрх	14.30%	85.70%
3	Уурлах бачимдах	43.80%	56.20%
4	Зожиг, ганцаардмал байдлыг хүсэх	28.10%	71.90%
5	Өөртөө итгэлгүй болох	14.10%	85.90%
6	Амьдралын утга учир алдагдсан мэт санагдах	14.70%	85.30%
7	Болгоомжлол, айдас түгшүүр мэдрэх	39.90%	60.10%
8	Дотоод хяналтаа алдах	6.10%	93.90%
9	Санаа зовнил ихсэх	56.40%	43.60%
10	Баяр баясгалан мэдрэхгүй болох	17.00%	83.00%
11	Төвлөрөх гэж удах	33.60%	66.40%



Шүүгч нарт сүүлийн 6 сарын хугацаанд эрүүл мэндийн стрессийн нойргүйдэл 56.2 хувь, толгой өвдөх 55.0 хувь, амархан ядрах сульдах 56.4 хувь, сэтгэл зүйн стрессийн уурлах бачимдах 43.8 хувь, болгоомжлол, айдас түгшүүр мэдрэх 39.9 хувь, санаа зовнил ихсэх 56.4 хувь шинжүүд илэрч байна. Дээрх бие махбод болон сэтгэл зүйн стрессийн хосолмол шинж тэмдэг 50 хувиас дээш илэрч байгаа нь 11.0 хувь байна. Шүүгч нарын ажлын ачаалал их, янз бүрийн сөрөг мэдээлэл, олон янзын ааш зан, авир төрхтэй хүмүүстэй харилцаж шийдвэр гаргадаг. Хууль эрх зүйн дагуу шийдвэр гаргадаг хэдий ч аль нэг тал нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх, олон нийтийн хардлага зэрэг нь сэтгэл зүйн болон эрүүл мэндийн хэвийн байдлыг алдагдуулж байна.

График №7


Дээрх шинж тэмдгүүдийг эмчлэх гэж оролдож байсан уу?



Тогтмол хэрэглэдэг эм, эмийн бус бүтээгдэхүүн бий юу? Ар гэрийнхэн амрах, ажлаа солих

График №8.

График №9.




Эдгээрээс харахад дээрх зовиуруудыг эмчлэх, ямар нэгэн арга хэмжээ авдаггүй болох нь 60 хувиас илүү байна. Хэрэглэж байгаа эм нь өвчин намдаах эм, толгойны эм, зүрх судасны эм, тархины цусан хамгамж сайжруулах эм гэх мэт эмнүүдийг хэрэглэж өвдөлтөө намжаадаг. Мөн гэр бүл найз нөхдийн зүгээс амрах хэрэгтэй, ажлаа солих хэрэгтэй гэж хэлж байсан 26,5 хувь байна.

## Хоёр. Сэтгэл зүйн үйлчилгээний хэрэгцээ шаардлага, хамрагдсан байдал, үр нөлөө

График №10.

Та мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзаж, тусламж авч байсан уу?



Судалгаанд оролцогчдын 97 хувь нь мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзаж байгаагүй, 53,1 хувь нь сэтгэл зүйн сургалт болон бусад үйл ажиллагаанд хамрагдаж байгаагүй байна. Үүнийг нийслэл болон орон нутгаар ялгаж авч үзвэл:

Хүснэгт №9.

Сэтгэл зүйн сургалтад хэдэн удаа хамрагдаж байсан бэ?

№	Үзүүлэлт	Нийслэл	Орон нутаг	Нийт
1	1 удаа	22.90%	27.10%	25.80%
2	2 удаа	12.40%	19.10%	17.00%
3	3 удаа	1.90%	5.10%	4.10%
4	Огт хамрагдаж байгаагүй	62.90%	48.70%	53.10%
	<b>Нийт</b>	<b>100.00%</b>	<b>100.00%</b>	<b>100.00%</b>

Сэтгэл зүйн сургалтад судалгаанд оролцогчдын 46.9 хувь нь хамрагдсан бөгөөд сургалтын агуулгаас ямар нэгэн мэдлэг, чадвар, дадлыг олж аваагүй нь 38.3 хувь, үлдсэн 61.7 хувь нь тодорхой хэмжээнд олж авсан сэтгэл зүйн мэдлэг, чадвараа ажил мэргэжил болон гэр бүлдээ 1 жилээс дээш хугацаанд хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №10.

Сэтгэл зүйн сургалтын агуулгаас өөрийн ажил мэргэжил болон гэр бүлийн орчинд авч хэрэгжүүлсэн өөрчлөлт бий юу?


№	Үзүүлэлт	Нийслэл	Орон нутаг	Нийт
1	Ажил, амьдралаа ялгаж сурсан	10.5%	9.8%	10.0%
2	Гэр бүл, үр хүүхэдтэйгээ харилцаа, хандлага өөрчлөгдсөн	2.6%	11.0%	8.3%
3	Өөрийгөө тайвшруулах, хүлээцтэй байх, бусдыг сонсог	26.3%	30.5%	29.2%
4	Стрессийг даван туулах арга	2.6%	14.6%	10.8%
5	Байхгүй	55.3%	30.5%	38.3%
6	Маш их мэдээлэл авсан	2.6%	3.7%	3.3%
7		100.0%	100.0%	100.0%

Хүснэгт №11.

Өмнөх сургалтаас олж авсан эерэг зөв гэсэн зүйлийг хэр удаан хугацаанд хэрэгжүүлж байгаа вэ?

№	Үзүүлэлт	Нийслэл	Орон нутаг	Нийт
1	1-3 сар	34.1%	26.4%	28.7%
2	4-6 сар	31.8%	12.3%	18.0%
3	1 жил ба түүнээс дээш	34.1%	61.3%	53.3%
4		100.0%	100.0%	100.0%

График №11. Шүүхийн сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай гэж бодож байна уу?



Шүүхийн хэмжээнд сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай гэж нийт судалгаанд оролцсон шүүгчдийн 91.3 хувь нь, тэр дундаа орон нутагт нэн шаардлагатай гэж 92.0 хувь үзсэн байна. Харин судалгаанд оролцсон нийт шүүгчдийн 8.7 хувь нь шүүгч хүн өөрийн сэтгэл зүйн асуудлыг бүрэн шийдэж чаддаг байх ёстой, өөрийн сэтгэл зүйг удирдаж хянаж сурсан тус сэтгэл зүйч ажиллах шаардлагагүй гэж хариулсан байна.

Хүснэгт №12.

Тийм бол яагаад шаардлагатай вэ?

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь
1	Ажлын стресс ихтэй	122	50.4%
2	Өөрийгөө удирдах, тайвшрах	55	22,7%
3	Хэргийн оролцогчид ба бусдыг таних, харилцах	17	7%
4	Мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөө шаардлагатай	33	13,6%
5	Нийгэм, улс төрийн нөлөө, шүүгчийн нэр хүнд	15	6,2%
6	<b>Нийт</b>	<b>242</b>	<b>100%</b>
7	Хариулаагүй	114	
	<b>Нийт</b>	<b>356</b>	

График №12.

Яагаад шаардлагатай вэ?



Хүснэгт №13.

Үгүй бол яагаад шаардлагагүй вэ?

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь
1	Өөрийн сэтгэл зүйг бүрэн хянаж сурсан, ямар ч нөлөөнд автдаггүй	23	100%
2	Хариулаагүй	333	
	<b>Нийт</b>	<b>356</b>	

Хүснэгт №14.

Сэтгэл зүйн үйлчилгээний нэн түрүүнд шаардлагатай байгаа үйлчилгээний төрөл юу вэ?

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь (тоололт)	Хувь (хүн)
1	Санаа бодлоо хуваалцах, алжаал тайлах тав тухтай орчин	215	24.1%	62.7%

2	Ганцаарчилсан оношлогоо, зөвлөгөө	149	16.7%	43.4%
3	өдөр тутамд хэрэглэж болох сэтгэл зүйн дасгал тоглоом сорил асуулга	109	12.2%	31.8%
4	Сэтгэл зүйн тест, оношлогоо, судалгаа	47	5.3%	13.7%
5	Сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтууд	204	22.9%	59.5%
6	Сэтгэл засал, тусгай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	101	11.3%	29.4%
7	Клиник эмчилгээ, ховс, эмийн эмчилгээ	66	7.4%	19.2%
	<b>Нийт</b>	<b>891</b>	<b>100.0%</b>	


Хүснэгт №15

Сэтгэл зүйн үйлчилгээний аль хэлбэр тохиромжтой вэ?

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь (тоололт)	Хувь (хүн)
1	Ганцаарчилсан	222	54.5%	66.1%
2	Бүлгийн ярилцлага	79	19.4%	23.5%
3	Онлайн мэдээлэл	25	6.1%	7.4%
4	Танхимын сургалт	81	19.9%	24.1%
5	<b>Нийт</b>	<b>407</b>	<b>100.0%</b>	

График №13.

Сэтгэл зүйн үйлчилгээний хэлбэр



Шүүхийн сэтгэл зүйн үйлчилгээнд санаа бодлоо хуваалцах, алжаал тайлах тав тухтай орчин 62.7 хувь, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө 66.1 хувь, танхимын сургалтууд 59.5 хувь тус тус нэн шаардлагатай байна.

Хүснэгт №16.

Танд шүүхийн сэтгэл зүйчтэй уулзаж, тусламж зөвлөгөө авахад бэрхшээлтэй асуудал үүсдэг?

№	Үзүүлэлт	Нийслэл	Орон нутаг	Нийт
1	Цаг зав боломж нөхцөл байхгүй	49.5%	37.5%	41.3%
2	Шүүхийн ёс зүйн хороо ойр учир очдоггүй	1.0%	.5%	.6%
3	Хувийн асуудлаа бусдад яриад байх шаардлагагүй	30.3%	18.5%	22.2%
4	Сэтгэл зүйчийн туршлага, мэдлэг хангалттай бус	2.0%	1.9%	1.9%
5	Боддог боловч хүмүүсээс санаа зовдог	1.0%	2.3%	1.9%
6	Сэтгэл зүйч байхгүй, байдаг гэдгийг мэдэхгүй	16.2%	39.4%	32.1%
	<b>Нийт</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>

Шүүхийн сэтгэл зүйчтэй уулзахад үүсдэг бэрхшээл нь нийслэлд цаг зав, боломж нөхцөл байхгүй гэж 49.5 хувь, орон нутагт сэтгэл зүйч байхгүй гэж 39.4 хувь, шүүхийн сэтгэл зүйч ажилладаг гэдгийг мэддэггүй гэж 32.1 хувь нь үзсэн байна.


Хүснэгт №17.

Шүүхийн сэтгэл зүйн алба нь байршлын хувьд хаана, ямар цагийн хуваариар ажиллавал тохиромжтой вэ?

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь
1	Шүүх бүр дээр тусгай мэргэжлийн сэтгэл зүйч тогтмол ажиллах	196	61,1%
2	Тусгай байранд,	100	31,2%
3	Бүсчилж, хуваарь гарган томилолтоор ажиллах	25	7,8%
4	Нийт	321	100
5	Хариулаагүй	35	
		356	

График №14.

Сэтгэл зүйчийн ажиллах нөхцөл



Шүүгч нарын хувьд шүүх бүр дээр мэргэжлийн сэтгэл зүйч тогтмол ажиллах нь 61.1 хувь, шаардлагатай үед хэзээд хандахад бэлэн нь 47.6 хувь, сайн дураараа оролцох нь 68.4 хувь байна. Энэ нь шүүхийн тамгын газарт сэтгэл зүйч тогтмол ажиллах, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө авах санаа бодлоо хуваалцах тав тухтай орчин нэн түрүүнд шаардлагатай байгаа нь харагдаж байна.


Хүснэгт №18.

Шүүхийн салбарт сэтгэл зүйн үйлчилгээ нэвтрүүлэхэд таны зүгээс хэрхэн оролцох вэ?

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь
1	Албан шаардлагаар	18	5,2%
2	Сайн дураараа	236	68,4%
3	Оролцох шаардлагагүй	31	9%
4	Оролцохыг хүсдэг боловч цаг зав, боломж байхгүй	60	17,4%
5	Нийт	345	100%
6	Хариулаагүй	11	
7	Нийт	356	

График №15.

Сэтгэл зүйн үйлчилгээнд оролцох хүсэл сонирхол



Хүснэгт №19.

Сэтгэл зүйн үйлчилгээний давтамж таны бодлоор хэр хугацаанд байвал тохиромжтой вэ?

№	Үзүүлэлт	Тоололт	Хувь
1	Улиралд 1 удаа	79	23,8%
2	Сард 1 удаа	19	5,7%
3	Сард 2 удаа	9	2,7%
4	Жилд 2 удаа	67	20,2%
5	Шаардлагатай үед хэзээ ч хандахад бэлэн байх	158	47,6%
6	<b>Нийт</b>	<b>332</b>	<b>100%</b>
7	Хариулаагүй	24	
8	<b>Нийт</b>	<b>356</b>	



## Дүгнэлт

Шүүхийн судалгаа мэдээлэл сургалтын хүрээлэнгээс шүүгч нарт сэтгэл зүйн үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор нэлэнхүй түүврийн аргаар, бүх шүүгч нарыг судалгаанд хамруулахыг хичээн санал асуулга явуулж 70.0 хувийн хамрагдалттайгаар үр дүнг тайлагналаа. Судалгааны асуулгын үр дүнд сэтгэл зүйн үйлчилгээний аль нэг төрөлд хамрагдаж байсан эсэх, шүүхийн хэмжээнд сэтгэл зүйч болон сэтгэл зүйн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, ажил мэргэжлийн онцлогтой холбоотой үүсч буй бэрхшээл саад, хамрагдах нөхцөл боломжийн түвшинг илрүүлж үүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хүргүүлж байна.

Судалгааны асуултууд өөр өөрийн онцлогтой, зорилготойгоор тавигдсан бөгөөд зарим асуулт, асуудлыг нэг бус удаа давтамжтай судалснаар илүү бодит үр дүнд хүрэх боломжтой юм.

- Шүүгч нарт бусдын өмнө өндөр хариуцлага хүлээх, нийгэм болон бусад хүмүүсээс тусгаарлагдмал, олон төрлийн хэргийн оролцогч нартай харилцаж өдөр тутамдаа ачаалал ихтэй ажиллаж байгаа нь тэдний сэтгэл зүйд болон эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг нь харагдаж байна.
- Энэхүү ажил мэргэжлийн онцлогоос хамаарч бий болж буй асуудлыг өөртөө хадгалж, ажлын онцлог гэж бодон хэсэг хугацааны дараа мартдаг, кофе уух, тамхи татах, гадаа гарч салхилах зэргээр өөрөө өөрийгөө тайвшруулдаг, хамт олон болон мэргэжил нэгт хүмүүстэй ярилцаж, зөвлөгөө авдаг гэх мэт арга замуудаар даван туулж байна.
- Чөлөөт цагаа өнгөрүүлдэг болон урам зориг авдаг объект нь гэр бүл, хамт олон, ном, спорт /иог, бясалгал/ зэрэг бол ямар нэгэн үйл ажиллагаанд оролцдоггүй, хариулаагүй 35,7 хувь байгаа нь ажлын стрессээ хэрхэн тайлдаг болон нь тодорхойгүй байна.
- Ажлын ачаалал, онцлогоос хамаарч нойргүйдэх, толгой өвдөх, амархан ядрах гэх мэт эрүүл мэндийн стрессийн шинж тэмдэг нийт шүүгчдийн 50-иас дээш хувьд нь, санаа зовнил ихсэх, уурлах бачимдах гэх мэт сэтгэл зүйн стрессийн шинж тэмдэг 40-өөс дээш хувьд нь илэрч, мөн хосолмол шинж тэмдэг нь 50 хувиас дээш илэрч байгаа нь 11.0 хувь байна. Энэ нь зөвхөн өвчин намдаах эмийн хэрэглээгээр /40.0 хувь/ тухайн үедээ намжаах бус ажил амралтаа зөв зохицуулах, алжаал ядаргааг тайлах, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн дархлааг дэмжих шаардлагатайг харуулж байна.
- Шүүгч нар өмнө нь сэтгэл зүйчтэй уулзаж, ярилцаж байгаагүй 97.0 хувь, шүүхэд сэтгэл зүйд ажилладаг эсэхийг мэдээгүй 32.1 хувь, өмнө нь сэтгэл зүйн сургалтад хамрагдаж байгаагүй 53.1 хувь байгаа нь энэ салбарт сэтгэл зүйч болон сэтгэл зүйн үйлчилгээ хангалтгүй байгааг харуулж байна.
- Сэтгэл зүйч, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ шаардлагатай гэж судалгаанд оролцогчдын 91.0 хувь, үлдсэн 9.0 хувь нь өөрийн сэтгэл зүйг бүрэн хянаж чаддаг гэж үзсэн байна.
- Шүүхийн тамгын газруудад мэргэжлийн сэтгэл зүйч тогтмол ажиллуулах /61.0 хувь/, санаа бодлоо хуваалцах, алжаал тайлах тав тухтай орчин бий болгох /62.7 хувь/, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө /66.1 хувь/ болон танхимын сургалт/59.1 хувь/ тус тус нэн шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнгээр илэрч байна.
- Шаардлагатай үед сэтгэл зүйч бэлэн байвал /47.6 хувь/, сайн дураараа хандахад бэлэн гэж судалгаанд оролцогчдын 68.4 хувь нь хариулсан байна.

## Санал зөвлөмж

- Шүүгч нарт сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх тав тухтай, алжаал тайлах тоног төхөөрөмж бүхий төв байгуулах. Энэ нь эхний ээлжид нийслэл дэх шүүхийн тамгын газруудад байгуулах ба шүүхийн тамгын газар тус бүрт сэтгэл зүйчийг тогтмол ажиллуулах;
- Орон нутагт сэтгэл зүйчийн нөөц боломж бага байгаа учир хуваарь гарган сэтгэл зүйчдийг томилолтоор ажиллуулах. Ингэхдээ тодорхой чиг үүргийн хуваарийн дагуу мэргэжлийн сэтгэл зүйчдээс томилох /орон нутагт сэтгэл зүйч байхгүй, итгэлцэл төрдөггүй болох нь судалгааны нээлттэй асуулгуудад дурдагдсан байна./
- Сэтгэл зүйн үйлчилгээний тодорхойлолтыг боловсронгуй болгож, зохион байгуулалтын нэгдсэн бодлого боловсруулах;
- Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын орчин нөхцөл, үйлчилгээний төрөл, санхүүгийн тооцоолол, хүний нөөцийн талаар судалгаа хийж сэтгэл зүйн үйлчилгээний загвар стандарт гаргах;
- Энэхүү судалгаанд үндэслэн олон улсын байгууллага болон хөрөнгө оруулах боломжтой байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөл боломжийг эрж хайх;
- Шүүхийн хэмжээнд сэтгэл зүйч ажиллаж, өөрсдөө сайн дураараа сэтгэл зүйн үйлчилгээ авах, боломжтой гэдгийг таниулах нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах.

Тайлан боловсруулсан:

Хянасан:

ШСМСХ-ийн сэтгэл зүйч Б.Нямаа

ШСМСХ-ийн захирал Ц.Мандах

